

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны ... дугаар сарын ...-ний өдөр
Улаанбаатар хот, Төрийн ордон

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ

/“Төрийн мэдээлэл”, 2014 он, №.../

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Онцгой байдлын албаны чиг үүрэг, тогтолцоо, зохион байгуулалт, удирдлага, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж

2.1. Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Төрийн албаны тухай², Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль³, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн 7.1-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулна.

3.2. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгжийн энэ хуулийн 15.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

3.3. Олон Улсын аврагчийн багийн аврах ажиллагаатай холбоотой харилцааг Гамшгаас хамгаалах тухай хуулиар зохицуулна.

4. дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “Онцгой байдлын төв байгууллага” гэж онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

¹Монгол Улсын Үндсэн хууль -“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

²Төрийн албаны тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн оны дүгээрт нийтлэгдсэн

³Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль –“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн оны дүгээрт нийтлэгдсэн

4.1.2.“нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага” гэж онцгой байдлын төв байгууллагын харьяа аймаг, нийслэл, дүүрэг дэх онцгой байдлын газар, хэлтсийг;

4.1.3.“алба хаагч” гэж онцгой байдлын албаны төв болон нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага, харьяа бүтцийн нэгжид ажиллаж байгаа энэ хуульд заасан тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчийг;

4.1.4.“аврагч” гэж тусгай мэргэжлийн сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн алба хаагчийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

5 дугаар зүйл. Онцгой байдлын алба

5.1. Онцгой байдлын алба нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд удирдан зохион байгуулах замаар Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бие даасан байгууллага байна.

5.2. Онцгой байдлын алба нь төрийн тусгай алба мөн.

6 дугаар зүйл. Онцгой байдлын албаны туг, бэлгэдэл

6.1. Онцгой байдлын алба нь туг, бэлгэдэлтэй байна.

6.2. Онцгой байдлын албаны туг, бэлгэдлийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

6.3. Бусад этгээдэд Онцгой байдлын албаны туг, бэлгэдэл, цол, дүрэмт хувцастай ижил загварын туг, бэлгэдэл, дүрэмт хувцас хэрэглэхийг хориглоно.

7 дугаар зүйл. Онцгой байдлын албаны үндсэн чиг үүрэг

7.1. Онцгой байдлын алба нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх;

7.1.2. гамшгийн аюулаас авран хамгаалах;

7.1.3. Гамшгаас учирсан хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох.

8. дугаар зүйл. Онцгой байдлын албаны нийтлэг зарчим

8.1. Онцгой байдлын албанд Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль², Галын аюулгүй байдлын тухай хуульд³ заасан зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтлана:

²Гамшгаас хамгаалах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн

³Галын аюулгүй байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 27 дугаарт нийтлэгдсэн

8.1.1. алба хаагч бүр гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцдог байх;

8.1.2. шинжлэх ухаан, техник, технологийн орчин үеийн ололтыг ашиглах;

8.1.3. албан үүргийн дагуу олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгалах;

8.1.4. шуурхай байх;

9. дүгээр зүйл. Онцгой байдлын алба хаагчийн тангараг

9.1. Онцгой байдлын албанд анх орохдоо “Монгол Улсын иргэн би онцгой байдлын албанд орж ажиллахдаа төрийн хуулийг дээдлэн, хүлээсэн үүргээ үнэнч шударгаар биелүүлж, шаардлага гарвал амь насаа үл хайрлан тэмцэхээ батлан тангараглая.

Би энэ тангарагаас няцваас хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.” хэмээн тангараг өргөнө.

9.2. Тангараг өргөх ёслолын журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10. дугаар зүйл. Онцгой байдлын албаны тогтолцоо

10.1. Онцгой байдлын алба нь онцгой байдлын төв байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага, тэдгээрийн харьяа нэгжээс бүрдэнэ.

10.2. Онцгой байдлын албаны орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, зохион байгуулалтын бүтцийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

11. дүгээр зүйл. Онцгой байдлын төв байгууллага

11.1. Онцгой байдлын төв байгууллагын бүтцэд дараах асуудал хариуцсан үндсэн нэгжүүд байна:

11.1.1. захиргааны удирдлагын;

11.1.2. урьдчилан сэргийлэх;

11.1.3. авран хамгаалах, гамшгийн хор уршгийг арилгах;

11.1.4. улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох;

11.1.5. санхүү хангалт-үйлчилгээний;

11.1.6. аюулгүй байдал-хяналтын.

11.2. Онцгой байдлын төв байгууллагын харьяа нэгжийг нутаг дэвсгэр, байгаль орчин, нийгэм, эдийн засаг, гамшгийн нөхцөл байдлын онцлогийг харгалзан Засгийн газар байгуулна.

11.3. Онцгой байдлын төв байгууллагын харьяанд аврах анги, шуурхай удирдлага- зарлан мэдээлэх нэгж, судалгаа шинжилгээ, сургалт-дадлагын болон ашиглалт, хангалт-үйлчилгээ, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ, эрүүл мэнд-сэргээн засах, биеийн тамир, соёлын асуудал хариуцсан нэгж байж болно.

12. дугаар зүйл. Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага

12.1. Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага нь энэ хуульд заасан үндсэн чиг үүргийг тодорхой нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх онцгой байдлын газар, хэлтэс түүний харьяа аврах анги, салбараас бүрдэнэ.

12.2. Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага нь урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох асуудал хариуцсан болон хэвийн үйл ажиллагааг хангах нэгж, алба хаагч, ажилтантай байна.

Тайлбар: “ажилтан” гэснийг Хөдөлмөрийн тухай хуульд⁴ зааснаар ойлгоно.

13. дугаар зүйл. Аврах анги, салбар

13.1. Аврах анги, салбар нь гамшгийн голомтод шуурхай шилжин байрлаж эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх, байгаль орчин, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үүрэг бүхий нэгж байна.

13.2. Аврах анги, салбар нь гамшгийн голомтод эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагааг холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулна.

14. дүгээр зүйл. Аюулгүй байдал -хяналтын нэгж

14.1. Аюулгүй байдал-хяналтын нэгж нь Онцгой байдлын алба, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, албаны хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

14.1.1. Онцгой байдлын байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах хүрээнд:

14.1.1.1. шаардлагатай үед аврах ажиллагааны аюулгүй байдлыг хангах,

14.1.1.2. эрх бүхий байгууллагын хүсэлтээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан талаарх тайлбар гаргах;

14.1.1.3. хуульд заасан бусад.

14.1.2. Албаны хяналтын хүрээнд:

14.1.2.1. Онцгой байдлын албаны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх

14.1.2.2. сахилга, ёс зүй зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

14.1.2.3. алба хаагчийн хууль ёсны эрх, эрх чөлөөг хамгаалах;

14.1.2.4. хуульд заасан бусад.

14.2. Аюулгүй байдал -хяналтын нэгжийг бусад чиг үүрэг хариуцсан нэгжээс бие даасан хэлбэрээр байгуулна.

14.3. Аюулгүй байдал-хяналтын нэгжийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг онцгой байдлын төв байгууллагын дарга тогтооно.

15. дугаар зүйл. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгж

15.1. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх нэгж нь байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн, мал амьтны гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон үед шуурхай удирдлагыг зохион байгуулах, нийтэд зарлан мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

⁴Хөдөлмөрийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт хэвлэгдсэн.

16. дүгээр зүйл. Судалгаа шинжилгээний нэгж

16.1. Судалгаа шинжилгээний нэгж нь энэ хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх талаар судалгаа хийх, лабораторийн шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг гүйцэтгэнэ.

16.2. Судалгаа шинжилгээний нэгж нь дараах үйл ажиллагааг явуулна:

16.2.1. Мэргэжлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулах;

16.2.2. стандарт, норм, дүрмийг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээ хийх;

16.2.3. дэвшилтэт техник, технологи, инновацийн талаар судалгаа хийх, зохион бүтээх ажил гүйцэтгэх;

16.2.4. зайнаас тандан судлах, гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх;

16.2.5. явуулын болон лабораторийн туршилт, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

16.2.6. нөөцийн бараа материалын хадгалалтын технологи, хорогдол, агуулах, савны стандарт, сэлгэлт, элэгдлийн талаар судалгаа хийх;

16.2.7. гамшгийн тухай мэдээ, тайлан гаргах

16.2.8. Онцгой байдлын төв байгууллагын даргын даалгасан бусад.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан судалгаа шинжилгээний нэгжийн дүрэм, бүтэц, орон тоог онцгой байдлын төв байгууллагын дарга тогтооно.

17. дугаар зүйл. Сургалт дадлагын нэгж

17.1. Онцгой байдлын төв байгууллагын харьяанд мэргэжлийн алба хаагчийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалт дадлагын бие даасан байгууллага байна.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан байгууллагад онцгой байдлын албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн бэлтгэлийг хангах нөхцөл, материаллаг орчин, байгууламж бүхий үйлдвэрлэл-дадлагын цогцолбор байна.

17.3. Сургалт дадлагын байгууллага нь дор дурдсан чиглэлээр сургалт-дадлагын үйл ажиллагааг явуулна:

17.3.1. Онцгой байдлын албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх мэргэжлийн;

17.3.2. алба хаагчийг мэргэшүүлэх давтан;

17.3.3. иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах;

17.3.4. албаны бусад.

17.4. Сургалт дадлагын байгууллагын эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг Шинжлэх ухаан технологийн тухай⁵, Дээд боловсролын тухай⁶, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль⁷ болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

⁵Шинжлэх ухаан технологийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 04 дүгээрт нийтлэгдсэн.

⁶Дээд боловсролын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

⁷Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2009 оны 10 дугаарт нийтлэгдсэн.

17.5. Сургалт дадлагын байгууллагын дүрэм, бүтэц, орон тоог онцгой байдлын төв байгууллагын дарга тогтооно.

18. дугаар зүйл. Техник ашиглалт, засварын нэгж

18.1. Техник ашиглалт, засварын нэгж нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны үед онцгой байдлын албаны техник хэрэгслийн бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж байна.

18.2. Техник ашиглалт, засварын нэгж нь техник, хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажиллах талаар дараах үүрэг хүлээнэ:

18.2.1. техникийн ашиглалт, засвар үйлчилгээг зохион байгуулж, явуулах тэдгээрт хяналт тавих;

18.2.2. тусгай зориулалтын техник хэрэгслээр аврах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг гүйцэтгэх;

18.2.3. хүн, мал амьтан, эд хөрөнгө, бараа материалыг тээвэрлэх;

18.3. Техник ашиглалт, засварын нэгжийн зохион байгуулалт, бүтэц, орон тоо, үйл ажиллагааны журмыг онцгой байдлын төв байгууллагын дарга батална.

19. дугаар зүйл. Эрүүл мэнд- сэргээн засах нэгж

19.1. Алба хаагчдад эмнэлэгийн тусламж үйлчилгээг үзүүлэх эмнэлэгийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл бүхий эрүүл мэнд-сэргээн засах нэгж байна.

19.2. Энэ хуулийн 19.1-д заасан нэгж нь нөхөн сэргээх, сэтгэл зүйн эмчилгээ үзүүлэх суурин болон явуулын эмнэлэгийн хэсэгтэй байна.

19.3. Суурин эмнэлэгийн хэсэг нь алба хаагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээс гадна нөхөн сэргээх, сэтгэл зүйн эмчилгээ болон аврагчийн сэтгэл зүйн талаарх судалгаа явуулна.

19.4. Явуулын эмнэлэгийн хэсэг нь гамшгийн аюулын голомтод үүрэг гүйцэтгэсний улмаас эрүүл мэндээр хохирсон алба хаагч, нэрвэгдэгсэдэд эмнэлэгийн анхны тусламж үзүүлнэ.

19.5. Эрүүл мэнд-сэргээн засах нэгжийн үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хууль⁸ болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

19.6. Эрүүл мэндийн нэгжийн дүрэм, бүтэц, орон тоог онцгой байдлын төв байгууллагын дарга тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ УДИРДЛАГА, ТЭДГЭЭРИЙН БҮРЭН ЭРХ

20. дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

20.1. Засгийн газар нь энэ хуулийн зорилтыг хэрэгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

⁸Эрүүл мэндийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

20.1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

20.1.2. онцгой байдлын албаны үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

20.1.3. гамшгаас хамгаалах асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах;

20.1.4. онцгой байдлын албыг зайлшгүй шаардлагатай тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, байгууламж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэлээр хангах;

20.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

21. дүгээр зүйл. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

21.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн зорилтын хүрээнд хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1. онцгой байдлын албаны нийгэм, эдийн засаг, эрх зүйн үндсийг хангах бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

21.1.2. онцгой байдлын албыг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах;

21.1.3. зайлшгүй шаардлагатай тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, байгууламж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх, нөхөн хангалтыг зохион байгуулах;

21.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

22. дүгээр зүйл. Онцгой байдлын албаны удирдлага

22.1. Онцгой байдлын алба нь нэгдмэл мэргэжлийн удирдлагатай байна.

22.2. Онцгой байдлын төв байгууллагын даргыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө.

22.3. Онцгой байдлын төв байгууллага нь энэ хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан тэргүүн дэд дарга, дотоод асуудал хариуцсан дэд даргатай байна.

22.4. Энэ хуулийн 22.3-т заасан тэргүүн дэд, дэд дарга нарыг онцгой байдлын төв байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

22.5. Онцгой байдлын төв байгууллагын даргын дэргэд түүний эрх хэмжээнд хамаарах асуудлаар орон тооны бус зөвлөх ажиллаж болно.

23. дугаар зүйл. Онцгой байдлын төв байгууллагын бүрэн эрх

23.1. Онцгой байдлын төв байгууллага нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна⁹ дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

⁹Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

23.1.1. төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

23.1.2. онцгой байдлын байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдал, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

23.1.3. алба хаагчийг Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан тохиолдолд энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах;

23.1.4. тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, байгууламж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэл ажил, үйлчилгээг шууд худалдан авах;

23.1.5. хууль заасан бусад бүрэн эрх

24. дүгээр зүйл. Онцгой байдлын төв байгууллагын даргын үүрэг, бүрэн эрх

24.1. Онцгой байдлын төв байгууллагын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1. холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

24.1.2. тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, байгууламж, хамгаалах хувцас, багаж хэрэгсэл бусад хангамжийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;

24.1.3. онцгой байдлын албаны үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;

24.1.4. онцгой байдлын албаны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг энэ хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн батлах, мөрдүүлэх;

24.1.5. хүний нөөцийн бодлого боловсруулж, алба хаагч, ажилтныг сургах, давтан сургах, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

24.1.6. онцгой байдлын албаны үндсэн чиг үүрэгтэй холбогдох асуудлаар онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлэл өгөх, санал тавих;

24.1.7. онцгой байдлын албыг төлөөлж гадаад, дотоодын байгууллагатай харилцах;

24.1.8. бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, цуцлах шийдвэр гаргах;

24.1.9. батлагдсан төсөв болон асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан байгууллагын орон тоо, цалингийн санг тогтоох;

24.1.10. ажилтан, алба хаагчийг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу томилох, чөлөөлөх, халах, цол олгох, сахилгын шийтгэл ногдуулах, сайшаал хүртээх, шагнаж урамшуулах;

24.1.11. онцгой байдлын төв байгууллагын батлагдсан төсвийг зохих журмын дагуу захиран зарцуулах;

24.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

24.2. Онцгой байдлын төв байгууллагын дарга бүрэн эрхийнхээ асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

24.3. Онцгой байдлын төв байгууллагын дарга хууль тогтоомжид заасан тодорхой бүрэн эрхээ энэ хуулийн 22.23-д заасан албан тушаалтанд шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

25. дугаар зүйл. Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллагын бүрэн эрх

25.1. Нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1. нутаг дэвсгэртээ энэ хуульд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх;

25.1.2. онцгой байдлын албаны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

25.1.3. байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

25.1.4. онцгой байдлын төв байгууллагад ажлаа тайлагнах, хариуцсан асуудлаар онцгой байдлын төв байгууллагын дарга, холбогдох албан тушаалтныг мэдээ мэдээллээр хангах;

25.1.5. онцгой байдлын албаны ажлын уялдааг хангах, зохицуулах, бусад байгууллагаас үүргээ гүйцэтгэхэд нь мэргэжлийн чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах.

25.2. Онцгой байдлын нутгийн захиргааны байгууллагын дарга нь эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АЛБА ХААГЧ ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

26. дугаар зүйл. Алба хаагч

26.1. Онцгой байдлын албаны алба хаагч нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох үүрэг бүхий төрийн жинхэнэ албан хаагч байна.

26.2. Аймгийн төвөөс бусад сумдад гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг үнэлэх, бууруулах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах асуудал хариуцсан байцаагч ажиллана.

26.3. Энэ хуулийн 26.2-д заасан гамшгаас хамгаалах асуудал хариуцсан байцаагч нь гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрхтэй онцгой байдлын алба хаагч байна.

27. дугаар зүйл. Аврагч

27.1. Энэ хуулийн 39.2 дүгээр зүйлд заасан шаардлага, шалгуурыг хангасан тусгай мэргэжлийн сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн алба хаагчийг аврагчаар томилно.

27.2. Аврагчийг дор дурдсанаар ангилна:

27.2.1. объектийн болон ой, хээрийн түймрийг унтраах, аврах аврагч-гал сөнөөгч;

27.2.2. ахуйн болон үйлдвэрлэл, техникийн ослоос аврах аврагч-техникч;

27.2.3. уснаас эрэн хайх, аврах аврагч-усчин, шумбагч;

27.2.4. тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох, аврах аврагч-тэсэлгээчин;

27.2.5. ой хээрийн түймэр унтраах, агаараас эрэн хайх, аврах аврагч-шүхэрчин гал сөнөөгч;

27.2.6. химийн аюултай ба хортой бодис, цацраг идэвхит бодис, биологийн хордолтыг аюулгүй болох, аврах аврагч-химичин;

27.2.7. тусгай зориулалтын техник, холбооны хэрэгслээр эрэн хайх, аврах аврагч-жолооч, аврагч-холбоочин;

27.2.8. уул, нурангид, уурхайд эрэн хайх, аврах аврагч-уулчин;

27.2.9. нэрвэгдэгсэдийг нохойгоор эрэн хайх, аврах аврагч-нохой хөтлөгч.

27.3. Онцгой байдлын алба нь Олон Улсын аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх аврагчийн багтай байж болно.

27.4. Олон Улсын аврагчийн багт энэ хуульд заасан I зэргийн аврагчаар 2-оос доошгүй жил ажилласан, гадаад хэлний мэдлэгийн зохих түвшинг хангасан алба хаагчийг томилно.

27.5. Энэ хуулийн 27.3-д заасан багт үүрэг гүйцэтгэх алба хаагчийг сонгон шалгаруулах журмыг онцгой байдлын төв байгууллагын дарга батална.

27.6. Олон Улсын аврагчийн багийн аврах ажиллагаатай холбоотой харилцааг Гамшгаас хамгаалах тухай хуулиар зохицуулна.

27.7. Онцгой байдлын албанд аврагчийн зөвлөл байгуулж болно. Аврагчийн зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг онцгой байдлын төв байгууллагын дарга батална.

28. дугаар зүйл. Аврагчийн мэргэжлийн зэрэг

28.1. Тусгай мэргэжил, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн, мэргэжлээрээ ажилласан хугацааны дор дурдсан шалгуурыг хангасан аврагч нь III, II, I, Олон Улсын мэргэшлийн зэрэг олгох шалгалтанд орох эрхтэй:

28.1.1. Аврагчийн мэргэжлийн III зэрэгт тусгай мэргэжлийн сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан;

28.1.2. Аврагчийн мэргэжлийн II зэрэгт тусгай мэргэжлийн 2-с доошгүй сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн, III зэргийн аврагчаар 2-с доошгүй жил мэргэжлээрээ 5-с доошгүй жил ажилласан;

28.1.3. Аврагчийн мэргэжлийн III зэрэгт тусгай мэргэжлийн 3-с доошгүй сургалтад хамрагдаж, аврах ажиллагааны арга, технологи эзэмшсэн, II зэргийн

аврагчаар 2-с доошгүй жил ажилласан, удирдах ба сурган зааварлах ажлын дадлагатай, мэргэжлээрээ 8-с доошгүй жил ажилласан;

28.1.4. Олон Улсын аврагчийн зэрэгт энэ хуульд заасан I зэргийн аврагчаар 2-оос доошгүй жил ажилласан, гадаад хэлний мэдлэгийн зохих түвшинг хангасан байхыг;

28.2. Аврагчийн мэргэжлийн зэргийг мэргэжлийн зэрэг олгох шалгалтад тэнцсэн тохиолдолд олгоно.

28.3. Олон Улсын аврагчийн багт энэ хуулийн 28.1.4-т заасан шалгуурыг хангасан алба хаагчийг томилно.

28.4. Аврагчийн мэргэжлийн зэрэг нь 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд дараагийн мэргэжлийн зэргийн шалгалт зохион байгуулагдаж дууссанаар хүчингүй болно.

28.5. Аврагчийн мэргэшлийн зэрэг олгох шалгалтын журмыг Засгийн газар батална.

29. дугаар зүйл. Аврагчийн тусгай хэрэгсэл

29.1. Аврагч үүргээ гүйцэтгэх үедээ бие хамгаалах тусгай зориулалтын хувцас, хэрэгслийг иж бүрдлээр хангагдана.

29.2. Аврагчийн гүйцэтгэх үүрэг, аврах ажиллагааны онцлог, төрлөөс хамаарч энэ хуулийн 29.1-д зааснаас гадна тусгай зориулалтын хэрэгслийг нэмж олгоно.

29.3. Энэ хуулийн 29.1-д заасан тусгай зориулалтын хэрэгслийн жагсаалт, түүнийг хэрэглэх, хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30. дугаар зүйл. Алба хаагчийн цол, дүрэмт хувцас, ялгах тэмдэг

30.1. Онцгой байдлын албаны тусгай алба хаагч нь цол, ялгах тэмдэг бүхий дүрэмт хувцас, тогтоосон журмаар үйлдсэн хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн тэмдэг, албаны үнэмлэх хэрэглэнэ.

30.2. Онцгой байдлын албаны тусгай алба хаагч нь дараах цолтой байна:

30.2.1. ахлагч нь онцгой байдлын дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч;

30.2.2. дунд офицер нь онцгой байдлын дэслэгч, ахлах дэслэгч, ахмад,

30.2.3. ахлах офицер нь хошууч, дэд хурандаа, хурандаа;

30.3. Онцгой байдлын төв байгууллагын даргад цэргийн дээд цол олгож болно.

30.4. Энэ хуулийн 30.2-д заасан цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар тогтооно.

30.5. Онцгой байдлын албаны цолны зэрэглэл болон Онцгой байдлын албанд алба хаах журам, хувийн дугаар бүхий офицер, ахлагчийн тэмдэг, албаны үнэмлэхний загвар, хэрэглэх журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус тогтооно.

31. дүгээр зүйл. Алба хаагчийн эрх

31.1. Алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ:

31.1.1. гамшгийн аюулын үед, сургалт дадлагад оролцох, жижүүрийн үүрэг гүйцэтгэх үедээ хоол, хүнс, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслэлээр хангагдахыг шаардах;

31.1.2. хууль тогтоомжоор хамгаалагдсан аливаа нууц мэдээ, мэдээлэлтэй танилцах эрх олгогдсон алба хаагч гүйцэтгэж буй албан үүргийн хүрээнд төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг задруулахгүй байх ;

31.1.3. гамшгын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн хор уршгийг арилгахын тулд тухай объектэд саадгүй нэвтрэх;

31.1.4. өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалуулах, зөрчигдсөн тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

31.1.5. албан тушаалын цалин хөлс, нэмэгдэл, тэтгэвэр, тэтгэмж, тусламж, нөхөх төлбөр, шагнал, урамшил авах, ээлжийн амралт эдлэх;

31.1.6. аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд оролцох үедээ гэмтэл, бэртэл авсан өвчилсөн тохиолдолд эмнэлэгийн байгууллагаар үнэ төлбөргүй үйлчлүүлэх;

31.1.7. дээд шатны албан тушаалтнаас өгсөн хууль бус үүрэг даалгаврыг биелүүлэхээс татгалзах;

31.1.8. Алба хаагч нь жилд 1 удаа эрүүл мэндийн оношлогоо, шинжлэгээнд хамрагдах;

31.1.9. хуульд заасан бусад эрх.

32. дугаар зүйл. Алба хаагчийн үүрэг

32.1. Алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэхээс гадна дараах үүргийг хүлээнэ:

32.1.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гамшгийн хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, хойшлуулашгүй сэргээн босгох үйл ажиллагаагааг хэрэгжүүлэхэд бэлэн байх, оролцох;

32.1.2. энэ хуулийн 32.1.1-д заасан үйл ажиллагаанд зохих журам, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахих, уг ажиллагаанд оролцож байгаа байгууллага, албан тушаалтан, иргэнд мэргэжлийн чиглэлээр зааварчилгаа өгч, туслалцаа үзүүлэх;

32.1.3. захирах, захирагдах ёсыг баримтлах, бусад удирдах албан тушаалтны өгсөн үүрэг, даалгаврыг шууд удирдах даргадаа мэдэгдэх;

32.1.4. хариуцсан техник, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангаж ажиллах;

32.1.5. өөрийн буруутай үйлдлээс онцгой байдлын албаны эд хөрөнгөд учруулсан бодит хохирлыг хохирлыг хариуцах;

32.1.6. үйл ажиллагаагаа эрх бүхий этгээдэд тайлагнах;

32.1.7. албан үүргээ гүйцэтгэхэд бусад этгээдээс нөлөөлсөн дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар удирдлагадаа мэдэгдэх;

32.1.8. сахилгын дүрэм болон холбогдох бусад дүрэм, журмыг чанд мөрдөх;

32.1.9. хуулиар хүлээсэн бусад.

32.2. Онцгой байдлын албаны алба хаагчийн сахилгын дүрмийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32.3. Энэ хуулийн 32.1.4-д заасан бэлэн байдлыг хангуулахтай холбогдон гарах зардлыг төр хариуцана.

33. дугаар зүйл. Алба хаагчид хориглох зүйл

33.1. Алба хаагчид дараах зүйлийг хориглоно:

33.1.1. багшлах, эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажил эрхлэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсран гүйцэтгэх;

33.1.2. дээд шатны албан тушаалтны хууль ёсны шийдвэр, тушаал, үүрэг даалгаврыг гүйцэтгэхээс татгалзах;

33.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүй албан ажлын мэдээ, мэдээллийг нийтэд болон бусдад мэдээлэх;

33.1.4. албаны бус зорилгоор байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, санхүүгийн эх үүсвэр, мэдээллийн хангамж болон албаны мэдээллийг ашиглах;

33.1.5. албан үүргээ гүйцэтгэх үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

33.1.6. энэ хуулийн 41.4-д зааснаар онцгой байдлын албанд үргэлжлүүлэн ажиллаж байгаа сургагч багш, зааварлагч эрэн хайх, аврах ажиллагаанд биечлэн оролцох;

33.1.7. хуулиар хориглосон бусад зүйл.

35.2. Онцгой байдлын алба, алба хаагчаар хуульд зааснаас өөр ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

АЛБА ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС, НӨХӨХ ТӨЛБӨР, ТУСЛАМЖ БОЛОН НИЙГМИЙН БАТАЛГАА

34. дүгээр зүйл. Алба хаагчийн цалин хөлс

34.1. Алба хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3-т заагдсан нэмэгдлээс бүрдэнэ.

34.1.1. төрийн алба хаасан хугацааны;

34.1.2. цолны;

34.1.3. онцгой нөхцөлийн;

34.1.4. хортой, хүнд нөхцөлд ажилласны;

34.1.5. хуульд заасан бусад.

34.2. Аврагчид мэргэжлийн зэргийн нэмэгдлийг дор дурьдсан хувь хэмжээгээр олгоно.

34.2.1. мэргэжлийн III зэрэгтэй аврагчид албан тушаалын үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний;

34.2.2. мэргэжлийн II зэрэгтэй аврагчид албан тушаалын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний;

34.2.3. мэргэжлийн I болон олон улсын зэрэгтэй аврагчид албан тушаалын үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний;

34.3. Цэргийн жинхэнэ алба хаасан, цэргийн болон онцгой байдлын албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуульд сонсогчоор суралцсан болон хуульд заасан бусад хугацааг онцгой байдлын албанд ажилласан хугацаанд оруулан тооцно.

Тайлбар: “сонсогч” гэдэгт онцгой байдлын албанд 2-с доошгүй жил ажиллаж, дээд боловсрол эзэмшихээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуульд суралцаж буй алба хаагчийг ойлгоно.

34.4. Гамшгийн голомтод ажилласан алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин өсгөж олгоно.

34.5. Алба хаагчид олгох албан тушаалын цалингийн хэмжээ, нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

35. дугаар зүйл. Алба хаагчид олгох нөхөх төлбөр

35.1. Алба хаагчид дараах нөхөх төлбөр олгоно;

35.1.1. алба хаагчид албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадварыг түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан хугацаанд нөхөн олгох, хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэхтэй холбогдон гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

35.1.2. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үед эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд түүнд дор дурдсан нэг удаагийн нөхөн төлбөрийг олгоно:

35.1.2.1. хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний;

35.1.2.2. хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг;

35.1.2.3. эмнэлгийн чөлөөтэй байсан хугацаанд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү;

35.1.2.4. тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, авч байсан цалингийн зөрүү.

35.2. Алба хаагчийн авч байсан цалингийн хэмжээ нэмэгдэх бүрт энэ зүйлийн 35.1.2.3, 35.1.2.4-т заасан цалингийн зөрүүг нэмэгдсэн цалингаас шинэчлэн тооцож олгоно.

35.3. Улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн доторхи нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-р зорчсон тохиолдолд хувиас гарсан зардлыг үйлчлүүлсэн баримтыг үндэслэн олгоно.

35.4. Энэ хуулийн-д заасан эрүүл мэндийн оношлогоо, шинжилгээнд хамруулахтай холбогдон гарах зардлыг төр хариуцана.

36. дугаар зүйл. Алба хаагчид олгох тусламж

36.1. Алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд энэ хуулийн 36.2-т заасан гэр бүлийн нэг гишүүнд албан хаагчийн сүүлд авч байсан нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг 10 жилийн туршид сар бүр олгоно.

36.2. Энэ хуулийн 36.1-д заасан тэтгэмж авах эрх нь албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчийн гэр бүлийн гишүүнд амь насаа алдсан өдрийн байдлаар дор дурьдсан дарааллаар үүсэх бөгөөд энэхүү эрх бусдад шилжихгүй.

36.2.1. тухайн алба хаагчтай гэрлэлтээ бүртгүүлсэн эхнэр /нөхөр/;

36.2.2. тухайн алба хаагчийн төрсөн болон үрчилсэн насанд хүрээгүй хүүхэд;

36.2.3. тухайн алба хаагчтай хамт амьдарч, асрамжид нь байсан эцэг, эх, насанд хүрээгүй дүү;

36.2.4. тухайн алба хаагчийн асрамжид бүрэн асрамжид байсан хөгжлийн бэрхшээлтэй төрсөн ах, эгч, дүү.

36.3. Онцгой байдлын албанаас чөлөөлөгдсөн алба хаагч мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хожим нас барсан бол энэ хуулийн 36.1-т заасан баталгаа нэгэн адил хамаарна.

36.4. Алба хаагч нь удирдлагынхаа шийдвэрээр онцгой байдлын алба дотор шилжин ажиллах болсноос шалтгаалан алба хаагчийн эхнэр (нөхөр) нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжинд түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах, ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байгаа хугацаанд Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний тусламжийг сар бүр нэг жилийн хугацаанд тухайн шилжин ажиллах онцгой байдлын байгууллагаас олгоно.

36.5. Онцгой байдлын албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуульд суралцаж буй сонсогчид суралцсан байдал, сурлагын голч дүнг харгалзан сургуулиа төгсөх хүртэлх хугацаанд Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээний тэтгэмж олгож болно.

36.6. Энэ хуулийн 36.5-д заасан тэтгэмж олгох журмыг Засгийн газар тогтооно.

37. дугаар зүйл. Алба хаагчийн баталгаа

37.1. Алба хаагч ажлын бус цагаар болон иргэд, байгууллагын хүсэлтээр хуульд заасан чиг үүргийн дагуу хууль ёсны үйл ажиллагаа явуулсан, түүнчлэн ажилдаа ирэх, буцах замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

37.2. Алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.

37.3. Алба хаагчийн жижүүрийн үүрэг гүйцэтгэсэн, шөнийн ээлжинд ажилласан, гамшгаас хамгаалах сургалт, дадлагад оролцсон, бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хоол хүнс, материалын зардлыг онцгой байдлын алба хариуцна.

37.4. Онцгой байдлын албаны тусгай алба хаагчийн алба хаасан хугацааг нь тогтооход ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар тооцно.

37.5. Алба хаагч нь амь насны, үйлдвэрлэлийн болон гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд төлбөрийг төр хариуцна.

37.6. Аймгийн төвөөс алслагдмал суманд тасралтгүй ажиллаж байгаа алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална.

37.7. Алба хаагчийг албаны орон сууцаар хангах асуудлыг Онцгой байдлын төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

37.8. Алба хаагч амины орон сууц барих, орон сууц худалдаж авахад нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу тусламж, хөнгөлөлт үзүүлж болно.

37.9. Онцгой байдлын албаны тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийг цэргийн жинхэнэ албанд татахаас чөлөөлнө.

37.10. Аврагч нь дээрх баталгаанаас гадна дараах эрүүл мэндийн баталгаагаар хангагдана:

37.10.1. цацраг, хими, хорт бодис, усны холбогдолтой ослын үед ажилласан тохиолдол бүрт хордлого тайлах эмчилгээнд хамрагдах;

37.10.2. амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлэгийн байгууллагаар эмчлүүлэх.

37.10.3. сэтгэл зүйн бэлтгэл хангах тусгай сургалтад хамрагдах;

37.11. Энэ хуулийн 37.10-д заасан баталгаа нь үнэ төлбөргүй байна. Үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх эмнэлэгийн байгууллагын жагсаалтыг Засгийн газар батална.

38. дугаар зүйл. Алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж

38.1. Алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох харилцааг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ БОЛЗОЛ, ЖУРАМ АЛБА ХААГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

39. дугаар зүйл. Албан тушаалд тавигдах шаардлага

39.1. Алба хаагч нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хор уршгийг арилгах, улсын нөөц-хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа явуулах мэдлэг, чадвар, дадлыг тогтоосон түвшинд хангасан байна.

39.2. Онцгой байдлын албаны албан тушаалд Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна дор дурдсан тусгай шаардлага тавигдана:

39.2.1. 18 насанд хүрсэн байх;

39.2.2. эрүүл мэнд, бие бялдарын;

39.2.3. сэтгэл зүйн;

39.2.4. ял шийтгэлгүй.

39.3. Энэ хуулийн 31.1-д заасан мэдлэг, чадвар, дадлын түвшинг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

39.4. Алба хаагчид тавигдах тусгай шаардлага болон мэдлэг, чадвар, дадлын түвшин тогтоох журмыг онцгой байдлын төв байгууллагын дарга батална.

40. дугаар зүйл. Ээлжийн амралт

40.1. Онцгой байдлын албаны тусгай алба хаагчид жил бүр ажлын 20, сонсогчид 25 өдрийн ээлжийн үндсэн амралт олгож, биеэр эдлүүлнэ.

40.2. Алба хаагчид төрийн алба хаасан таван жил тутамд ажлын 3 өдрийн нэмэгдэл амралт эдлүүлнэ.

41. дүгээр зүйл. Алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар

41.1. Алба хаагч нь:

41.1.1. ахлагчийн албыг 45 нас хүртэл;

41.1.2. дунд офицер 45 нас хүртэл;

41.1.3. ахлах офицер 50 нас хүртэл тус тус хааж болно.

41.2. Онцгой байдлын албаны эмэгтэй алба хаагч ахлагч, офицерын албыг цол харгалзахгүйгээр 45 нас хүртэл хааж болно.

41.3. Энэ хуулийн 41.1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн алба хаагчийн өөрийнх нь хүсэлтэд үндэслэн алба хаах хугацааг Онцгой байдлын төв байгууллагын дарга зөвшөөрсний үндсэн дээр онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тав хүртэл жилээр сунгаж болно.

41.4. Ахлагчийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн аврагчийн алба хаах хугацааг энэ хуулийн 41.3-д зааснаас гадна түүний мэргэжлийн зэрэг, туршлагыг харгалзан онцгой байдлын төв байгууллагын саналыг үндэслэн онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж, үргэлжлүүлэн сургагч багш, зааварлагчаар ажиллуулж болно.

41.5. Алба хаагч энэ хуулийн 41.1-д заасан насны дээд хязгаарт хүрмэгц албанаас чөлөөлөгдөх болон сунгуулах тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг албанаас чөлөөлөхөд саад болохгүй.

41.6. Энэ хуулийн 41.3, 41.4-д заасан хугацаа сунгах журмыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

41.7. Онцгой байдлын алба нь энэ хуулийн 41.1-д заасан насны дээд хязгаарт хүрч албанаас чөлөөлөгдсөн иргэнийг хуульд өөрөөр заагаагүй бол онцгой байдлын албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд туслах үүрэг бүхий ажилд гэрээгээр ажиллуулж болно.

42. дүгээр зүйл. Алба хаагчийг томилох

42.1. Онцгой байдлын албаны албан тушаалд Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг болон энэ хуульд заасан тусгай шаардлага, шалгуурыг хангасан этгээдийг томилно.

43. дугаар зүйл. Алба хаагчийг түр чөлөөлөх, чөлөөлөх

43.1. Алба хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 23.3-д зааснаас гадна дараах үндэслэлээр захиргааны санаачлагаар албан тушаалаас нь түр чөлөөлнө:

43.1.1. Эрх бүхий байгууллагаас алба хаагчийг албан тушаалаас нь түр чөлөөлөх хүсэлт гаргасан.

43.2. Алба хаагчийг Төрийн албаны тухай хуулийн 42.2-т зааснаас гадна дараах үндэслэлээр захиргааны санаачлагаар шууд чөлөөлнө.

43.2.1. өөр ажилд томилогдсон буюу сонгогдсон;

43.2.2. биеийн эрүүл мэндээр үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон нь магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон;

44. дугаар зүйл. Алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

44.1. Энэ хуулийн 32, 33 дүгээр зүйлд заасныг зөрчсөн болон алба хаагчид тухай зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэн эсэхийг харгалзан Төрийн албаны тухай хуулийн 26.1-д зааснаас гадна цол бууруулах буюу хураан авах сахилгын шийтгэл ногдуулна.

45. дүгээр зүйл. Алба хаагчийн шагнал, урамшил

45.1. Алба хаагч хуульд заасан үүргээ үр дүнтэй гүйцэтгэж, өндөр амжилт гаргасан гавьяа зүтгэлийг нь үнэлж төрийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаас гадна дараах урамшууллыг олгож болно.

45.1.1. Олон хүний амь нас, эрүүл мэнд, их хэмжээний эд хөрөнгийг аюултай нөхцөл байдлаас авран хамгаалсан алба хаагчид мөнгөн урамшил олгоно.

Тайлбар: “Олон хүн” гэдэгт 5 аас доошгүй хүнийг, “Их хэмжээ”-г Эрүүгийн хуульд зааснаар ойлгоно.

45.2. Алба хаагчид энэ зүйлийн 45.1.1-д зааснаас гадна улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгож болно.

45.3. Алба хаагчийг энэ зүйлийн 45.1.1-д заасан мөнгөн урамшил олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

45.4. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.

45.5. Онцгой байдлын алба, алба хаагчид бусад хууль тогтоомжид заасан шагнал, урамшил олгож болно.

46. дугаар зүйл. Алба хаагчийн хөдөлмөрийн бусад харилцаа

46.1. Онцгой байдлын албаны албан тушаалд сонгон шалгаруулах, алба хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, захиргааны санаачлагаар албан тушаалаас нь бууруулах, халах, онцгой байдлын албаны албан тушаалд анх орсон иргэнд туршилтын хугацаа хэрэглэхтэй холбогдсон харилцааг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШУУРХАЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

47. дүгээр зүйл. Онцгой байдлын албаны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах

47.1. Гамшгаас хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн бусад аюул тохиолдсон газарт очих, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай хүнийг эмнэлэгт хүргэх зорилгоор тээврийн хэрэгслийг дайчилна.

47.2. Гамшгийн аюултай холбоотой яаралтай мэдээллийг нийтэд түгээх шаардлагатай бол өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгслийг ашиглана.

47.3. Онцгой байдлын албаны тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэнэ.

47.4. Онцгой байдлын албаны авран хамгаалах үүргийг гүйцэтгэж яваа тусгай дуут, гэрэл дохиогоор тоноглогдсон автомашин, энэ хуулийн 47.1-д зааснаар дайчлагдсан тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөнд нь аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно.

47.5. Онцгой байдлын алба нь энэ хуулийн 47.1-т заасан ажиллагаанаас гарсан зардлыг нөхөн төлнө.

47.6. Алба хаагчид албан хэрэгцээний шаардлагын дагуу албаны болон хувийн тээврийн хэрэгсэл, уналгыг гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулж болно.

47.7. Онцгой байдлын албаны үйл ажиллагааны шуурхай байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ САНХҮҮЖИЛТ

48. дугаар зүйл. Онцгой байдлын албаны төсөв

48.1. Онцгой байдлын албаны төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлэх бөгөөд энэхүү төсөв нь уг байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүрэлцэхүйц хэмжээтэй байна.

48.2. Энэ хуулийн 48.1-д заасан шаардлагын хүрээнд хүнс, эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, аврах тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгайлан тусгаж санхүүжүүлнэ.

49. дугаар зүйл. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх

49.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь энэ хуульд заасан онцгой байдлын албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой нутаг дэвсгэр хариуцсан онцгой байдлын байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.

50. дүгээр зүйл. Онцгой байдлын албаны хөгжлийн сан

50.1. Онцгой байдлын төв байгууллага нь онцгой байдлын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хөгжлийн сантай байна.

50.2. Онцгой байдлын хөгжлийн сангийн дүрэм, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

51. дугаар зүйл. Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

51.1. Онцгой байдлын албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн онцгой байдлын албаны алба хаагчид холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

52. дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

52.1. Энэ хуулийг 2014 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ